

**Сайнцагаан сумын "Орлоготой - иргэн - сум" дэд хөтөлбөрийн хэрэгжилт**

2018.06.11

| <b>Зорилт</b>                          | <b>Үйл ажиллагаа</b>                                              | <b>№</b> | <b>Хийгдэх ажлууд</b>                                                                                                                                                                | <b>Хэрэгжилт</b>                                                                                                                                                                                                                              | <b>Хувь</b> |
|----------------------------------------|-------------------------------------------------------------------|----------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|
| Сумын орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх | Сумын хэмжээний бизнес эрхлэгчдийн судалгааг гаргаж бүртгэлжүүлэх | 1        | Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж байгаа иргэдийн тооллого, судалгааны аргачлалыг боловсруулна.                             | Суманд үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч болон, аж ахуй нэгж , үйлдвэрүүдийн дэлгэрэнгүй судалгаа гаргах маягыг боловсруулан гаргаж, судалгаа тооллогыг зохион байгуулсан.                                                | 100         |
|                                        |                                                                   | 2        | Тооллого судалгааг явуулна.                                                                                                                                                          | ААНэгж болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж байгаа иргэдийн тооллогоор сумын хэмжээнд Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч -95, Үйлдвэр аж ахуй нэгж -68, Гоёлын гоо заслын үйлчилгээ -40, Хүнсний худалдаа -68 иргэн үйл ажиллагаа явуулж байна. | 100         |
|                                        |                                                                   | 3        | Мэдээллийг боловсруулж мэдээллийн баазийг бий болгоно.                                                                                                                               | 2016, 2017, 2018 онуудад үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгч болон аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй судалгаатай болсон.                                                                                       | 100         |
|                                        |                                                                   | 4        | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээр төсөл бичин хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаж байгаа иргэдийг мэдээллийн сандаа тогтмол нэмж, тэдний үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлнэ. | СХСангаас хөнгөлөлттэй зээл олгосон иргэн аж ахуй нэгжүүдийг СХСангийн мэдээллийн сан болон, хөдөлмөрийн LMIS программд ажил олгогч болон шинэ ажлын байрыг бүртгэн авч байна.                                                                | 70          |
|                                        | Буутай иргэдийн судалгааг гаргаж, татварыг бүрэн төвлөрүүлнэ.     | 5        | Бууны бүртгэлийг цагдаагийн байгууллагатай хамтран үнэн зөв гаргах                                                                                                                   | 2018 оны галт зэвсэг эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, нийт 74 буу эзэмшигчдэд 3660.0 мянган төгрөгийн албан татвар ногдуулсан.                                                                                                      | 100         |
|                                        |                                                                   | 6        | Бүртгэлгүй бууг бүртгэх, бүртгэлээс хасах шаардлагатай бууг хасах ажлын зохион байгуулна.                                                                                            | Хугацаа болоогүй                                                                                                                                                                                                                              |             |

|                                                                                                                                       |    |                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|-----------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|                                                                                                                                       | 7  | Бүртгэлтэй бууны татварыг бүрэн төвлөрүүлнэ. Урьд оны тооцоотой бууны татварыг нөхөж авах.    | Урьд оны бууны татварын дутуу 60.0 мянган төгрөг, тайлант оны 615.0 мянган төгрөгийн албан татвар орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн. Үүнээс 1-р баг 90.0 төгрөг, 4-р баг 315.0 төгрөг, 6-р баг 60.0 төгрөг, 7-р баг 150.0 төгрөг 8-р баг 30.0 төгрөг, 9-р баг 30.0 төгрөгийн татвар тус тус төвлөрүүлсэн. Бууны албан татвар төлөх хуулийн хугацаа 12 сарын 1-нээр дуусна. | 100 |
| Хотын төвийн самбарыг бүртгэлжүүлж, гэрээ байгуулан бүрэн ашиглаж төлбөрийг төвлөрүүлнэ.                                              | 8  | Хотын сурталчилгааны самбаруудын судалгааг /талбайн хэмжээ, ашиглах тал г.м/ гаргаж бүртгэнэ. | Мандалговь хотын төвд байрлах сурталчилгаа, мэдээллийн томоохон самбаруудыг бүртгэж, эзэмшигчийг нь тодорхойлон тогтоосон. Нийт хотын төвд 26 ш самбар байгаагаас 2 ш сумын ЗДТГ-ын мэдэлд бусад нь ААН-үүдийн мэдэлд байна.                                                                                                                                                       | 100 |
|                                                                                                                                       | 9  | Самбарын засвар үйлчилгээг хийнэ.                                                             | Эзэмшигч ААН-үүдэд самбарын засвар үйлчилгээг хийж өнгө үзэмжийг сайжруулах талаар мэдэгдсэн. Одоогийн байдлаар 2 самбарт засвар хийгдсэн.                                                                                                                                                                                                                                         | 40  |
|                                                                                                                                       | 10 | Самбарыг ашиглуулах төлбөрийн хэмжээг тогтооно.                                               | ЗДТГ-ын эзэмшдэг сурталчилгааны самбарыг бусдад ашиглуулахад төлөх төлбөрийг хэмжээг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Энэ талаар судалж зохих шийдвэрийг гаргахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар 1м2 нь 5000 төгрөгний төлбөртэй байдаг.                                                                                                                       | 70  |
|                                                                                                                                       | 11 | Аж ахуй нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулан төлбөрийг төвлөрүүлнэ.                         | Самбарыг ашиглуулах талаар томоохон ААН-үүдэд санал хүргүүлээд байна. Хагас жилийн байдлаар 80.0 мянган төгрөгийг ОНОрлогод төвлөрүүлсэн.                                                                                                                                                                                                                                          | 40  |
| Улсын бүртгэлийн газартай хамтран иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сайжруулах, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг бодитой болгоно. | 12 | Шилжин явж байгаа иргэнийг тойрох хуудсаар тооцоо хийж шилжүүлнэ.                             | Сумаас шилжин явж байгаа иргэдийг сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтантай аливаа асуудлаар тооцоо нийлж байж шилжүүлэх зорилгоор тойрох хуудсыг зуруулж ажиллаж байна. Хагас жилийн байдлаар шилжин ирсэн 276, шилжин явсан 208 бүгд 484 иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэсэн.                                                                                                | 100 |
|                                                                                                                                       | 13 | Төрийн албан хаагчдын судалгааг гаргана.                                                      | Сумын ЗДТГазар болон бусад албан байгууллагуудад төрийн алба хашиж байгаа төрийн алба хаагчдын үндсэн харъяаллыг тодорхойлох судалдаг гаргах бэлтгэл ажил хийгдэж байна.                                                                                                                                                                                                           | 40  |

|  |                                                                                                 |    |                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |     |
|--|-------------------------------------------------------------------------------------------------|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|  |                                                                                                 | 14 | Төрийн албан хаагчдыг сумын иргэн болгох ажлыг зохион байгуулна.                                                                              | Сумын засаг даргын захирамжаар "Хаяг ба Хаягжуулалт" арга хэмжээ зохион байгуулж сумын төвийн 23 байгууллагын хаягийн өөрчлөлт хийлгээгүй иргэнийг илрүүлж зөрчлийн хуулийн дагуу арга хэмжээ авч 130.000 төгрөгийн торгууль ногдуулсан. Цаашид төрийн албан ажиллаж байгаа өөр сумын харъяатиргэдийг суманд шилжиж ирэх талаар анхаарч ажиллаж байна. | 100 |
|  |                                                                                                 | 15 | Үл хөдлөх хөрөнгийн мэдээллийн Улсын бүртгэлийн газраас гаргуулан авч бодит байдалтай тулган нягталж, орхигдсон үл хөдлөх хөрөнгийг бүртгэнэ. | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөөгүй үйл ажиллагаа явуулж буй ҮХЭХ-тэй иргэдтэй тухай бүр уулзаж хууль журмыг танилцуулж татварыг ногдуулдаг.                                                                                                                                                                                                  | 100 |
|  |                                                                                                 | 16 | Үл хөдлөх хөрөнгийн татварыг бүрэн төвлөрүүлнэ.                                                                                               | 2018 онд нийт 2100.0 төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төлөвлөгөөтэй 2307.8 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.                                                                                                                                                                                                                         | 100 |
|  | Нохой, муурны татварын журмыг хэрэгжүүлж, нэгдсэн бүртгэлтэй болгон татварыг бүрэн төвлөрүүлнэ. | 17 | Тэжээвэр нохой, муурны бүртгэл судалгааг үнэн бодитой гаргах                                                                                  | Сумын хэмжээнд тэжээвэр нохойны бүртгэл судалгаа гарсан. Нийт тэжээвэр нохойны тоо 403 байна. Үүнээс 1 р баг-29, 3 р баг-28, 4-р баг 57, 6-р баг -80, 7р баг-31, 8-р баг 85, 9-р баг -17 тэжээвэр нохойтой.                                                                                                                                            | 100 |
|  |                                                                                                 | 18 | Тэжээвэр нохой, муурны татвар бүрэн хурааж төвлөрүүлэх                                                                                        | Татварын бус орлогын дансанд нохой муурны татвар 661.0 мянган төгрөг төвлөрсөн. Үүнээс 3-р баг 60.0 төгрөг, 4-р баг 228.0 төгрөг , 7-р баг 100.0 төгрөг, 8-р баг 217.5 төгрөг, 9-р баг 55.5 мянган төгрөг тус тус төвлөрүүлсэн.                                                                                                                        | 70  |

|                                                       |                                                                                                               |    |                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |     |
|-------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| ААН-ийн орлогыг нэмэгдүүлж, ажлын байрыг бий болгоно. | Нийтийн хоол, зочид буудал, худалдаа, ахуй үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр боловсруулна. | 19 | Нийтийн хоол, зочид буудал, худалдаа, ахуй үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, сургалтуудыг зохион байгуулна.                                | "ХҮНС ҮЙЛДВЭРЛЭГЧ" нарт сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд 50 гаруй байгууллага, аж ахуй нэгж, иргэд оролцлоо. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг эрхэмлэе" сэдэвт сургалтыг зохион байгуулж, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын 28 ажилтан хамрагдлаа. Татварын хэлтэс, цагдаагийн газар, мэргэжлийн хяналтын газар, стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран үсчин гоо сайханчдад зөрчлийн тухай хууль, үс засах үйлчилгээ, гоёлын гоо заслын үйлчилгээ, ХАОАТ-ын тайлан гаргах тухай мэдээллүүдээр сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийт 17 үсчин, 5 гоёлын гоо заслын үйлчилгээ эрхлэгч иргэд хамрагдлаа. | 100 |
|                                                       |                                                                                                               | 20 | Нийтийн хоол, зочид буудал, худалдаа, ахуй үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжлэг үзүүлнэ.                                                   | Сум хөгжүүлэх сангаас олгодог бага хүүтэй зээлийг "Оргил бэйкэри", "Наран" зоогийн газарт 29,3 сая төгрөгний зээлийг олгохоор шийдвэрлээд байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 100 |
|                                                       |                                                                                                               | 21 | Дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн дунд төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулна.                                                  | хугацаа болоогүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |     |
|                                                       |                                                                                                               | 22 | Хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцож, дахин үнэлгээ хийж, жишиг үйлчилгээний газруудыг бий болгоно.                                                               | хугацаа болоогүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |     |
|                                                       | Үзэсгэлэн худалдаа зохион байгуулж бүтээгдэхүүнийг сурталчилна.                                               | 23 | "Цагаан сар", "Дундговь түншлэл", "Сайнцагаан түншлэл" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч ААН, иргэдийг идэвхитэй оролцуулна. | Монголын уламжлалт сар шинийн баярыг угтаж "Цагаан сар-2018" үзэсгэлэн худалдааг Дэлгэрхангай плаза худалдааны төвд 2 хоногийн турш зохион байгууллаа. Үзэсгэлэнд 37 иргэн аж ахуй нэгж оролцож 18,6 сая төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | 100 |
|                                                       |                                                                                                               | 24 | Улаанбаатар хотод Сайнцагаан сумын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах худалдааны өдөрлөг зохион байгуулна.                                                  | хугацаа болоогүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |     |

|                                                                                                                 |    |                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |     |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|                                                                                                                 | 25 | Дээрх үзэсгэлэнгүүд болон өдөрлөгт үйлдвэрлэл эрхлэгчид, малчдыг нэгдсэн зохион байгуулалттай оролцуулж сүү, цагаан идээ, айраг зэрэг бүтээгдэхүүнийг их хэмжээгээр бэлтгэх ажлыг зохион байгуулна.              | хугацаа болоогүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |     |
| Үйлдвэрлэл эрхлэгчдийг ижил төрлийн үйлдвэрлэлүүдтэй танилцуулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулна | 26 | Хөрш зэргэлдээ аймгуудад амжилттай ажиллаж байгаа үйлдвэрлэлүүдийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлыг зохион байгуулж үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор дэмжлэг авсан ААН, иргэдийг оролцуулна | Сумын Засаг дарга, МЭҮТасгийн дарга, МЭҮТасгийн мэргэжилтэн, хөдөөгийн 4 багийн дарга, “Үйзэн мандал”, “Аривжих далай”, “Бүрэн зост” хоршоонуудын төлөөллүүдийг оролцуулан Төв аймаг байрлах “Могол ноос” ХХК-ны үйл ажиллагаатай танилцах ажил зохион байгуулагдлаа.                                                                                                                                                                                                                                                              | 100 |
| Эрчимжсэн гахай тахианы аж ахуй, газар тариаланг дэмжинэ.                                                       | 27 | Сумын гахай, тахианы аж ахуй эрхлэлтийн өнөөгийн байдалд шинжилгээ хийнэ.                                                                                                                                        | Сумын хэмжээнд гахай, тахианы аж ахуй эрхлэлтийн өнөөгийн байдалд шинжилгээ хийхэд тахианы үйлдвэрлэл одоогоор байхгүй байна. Өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан 1 тахианы аж ахуй зогссон. Тиймээс тахианы аж ахуйг эрхлэх зах байна гэж үзэж байна. Гахайны аж ахуйн хувьд 2018 онд нийт 51 гахай тоологдсон байна. цаашид үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай.                                                                                                                                                              | 100 |
|                                                                                                                 | 28 | Энэ чиглэлээр аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдийг хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.                                                                                                                             | СХСангаас 2017 онд 9-р багийн иргэн Д.Галсандорж 10,0 сая, 2018 онд М.Мягмарнаранд 30,0 сая төгрөгний зээлийг олгосон. Тахианы аж ахуйг дэмжих зорилгоор 7-р багийн иргэн Г.Дашмаад 30,0 сая төгрөгний зээлийг олгохоор шийдвэрлээд байна.                                                                                                                                                                                                                                                                                         | 100 |
|                                                                                                                 | 29 | Дэмжлэг авах иргэдийг гахай, тахианы аж ахуй эрхлэх сургалтанд хамруулж үйл ажиллагааг эхлүүлнэ.                                                                                                                 | СХС-аас хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр төсөл хэрэгжүүлж байгаа болон сумын хэмжээний газар тариалан эрхлэгч, хоол, талх нарийн боов, сүү сүүн бүтээгдэхүүн мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн,хуулийн этгээд 50 хүн оролцсон сургалтыг 2018,04,06-нд зохион байгууллаа. Сургалтыг УБ хотын “Хөгжлийн шийдэл ТББ-ын сургалтын менежер, сургагч багш Г.Оюунгэрэл БҮТЭЭГДЭХҮҮН/ ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖҮҮЛЭЛТ, Бүтээгдэхүүн/ үйлчилгээний инноваци 4 цагийн сургалтыг амжилттай зохион байгуулж сургалтанд оролцогчдын талархлыг хүлээлээ. | 100 |

|                               |                                                                        |    |                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |     |
|-------------------------------|------------------------------------------------------------------------|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|                               |                                                                        | 30 | Газар тариалан, хүлэмжийн аж ахуйн эрхлэх иргэд, ААН-ийн санаачилгыг дэмжиж ажиллана.                               | Хүлэмжийн үйлдвэрлэл эрхлэх төсөл, санал санаачилгыг дэмжин СХСангаас өвлийн хүлэмж байгуулах 2 төсөлд 40,1 сая төгрөгний зээл олгохоор шийдвэрлээд байна.                                                                                                                                                                                                                                                                                                                       | 100 |
| Иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. | "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" аян зарлаж малчдын бүлгүүдийг байгуулна. | 31 | Малчин өрхүүд нэгдэж бүлэг, хоршоо байгуулан ажиллах талаар сургалт мэдээллийг малчдад өгөх                         | Швейцарын Хөгжлийн Агентлагийн "Ногоон алт" хөтөлбөрийн "Бэлчээрийн менежмент-Малын эрүүл мэнд" төслийн хүрээнд бэлчээр ашиглалтын хэсэг 4 байгуулагдсан. Үүнээс дундын сан бүхий 1 бэлчээр ашиглалтын хэсэг үйл ажиллагаа явуулж байна.                                                                                                                                                                                                                                         | 70  |
|                               |                                                                        | 32 | "Нэг суурин нэг бүтээгдэхүүн" аяныг зарлаж үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх санаачилга гаргасан малчдад дэмжлэг үзүүлнэ. | Сум хөгжүүлэх сангаас 2017 онд мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Мах утаж шарах зориулалтаар 1-р багийн иргэн Ц.Оюун-Эрдэнэд 5,0 сая төгрөгний зээлийг олгосон. 2018 онд давхар утлагтай махыг 300 граммаар 600 уут 500 граммаар 400 уут бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, 6.0 сая төгрөгний борлуулалтын орлогтой ажиллалаа. Сум хөгжүүлэх сангаас сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг дэмжих зорилгоор 3 иргэнд 30 сая төгрөгний зээл олгохоор шийдвэрлээд байна. | 100 |
|                               |                                                                        | 33 | Бүлэг, хоршоо болон амжилттай ажиллаж байгаа аймгийн туршлагыг судална. /Баянхонгор гэх мэт/                        | хугацаа болоогүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |     |
|                               | Ноос, арьс ширний урамшуулалд малчдыг бүрэн хамруулна.                 | 34 | Ноос, арьс ширний төлөөлөгч нартай хамтран ажиллаж урамшуулалд бүрэн хамруулах ажлыг хэрэгжүүлнэ.                   | Хонины ноосыг дотоодын "Могол ноос" ХХК-д нийлүүлэх, уг үйлдвэртэй сумын болон 4 багийн засаг дарга нар, хоршооны төлөөлөл, МЭҮТ-ийн мэргэжилтнүүд танилцаж хамтран ажиллах талаар санал солилцож хонины ноосыг бэлтгэн нийлүүлэхээр тохиролцсон.                                                                                                                                                                                                                                | 100 |

|                                                                                |    |                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |     |
|--------------------------------------------------------------------------------|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|                                                                                | 35 | Урамшууллыг малчдад олгоход хариуцлагатай сайн ажиллаж байгаа төлөөлөгчидтэй хамтран ажиллахыг малчдад сурталчилж урамшуулалд хамрагдсан малчдын тоог нэмэгдүүлнэ.  | Хөдөөгийн багуудад байгуулагдсан хоршоодыг дэмжих үүднээс ХХААЯ-ны МАА-н Эрдэм шинжилгээний хүрээлэн, “Могол ноос” ххк, Сайнцагаан сумын ЗДТГ хооронд хамтран ажиллах гурвалсан гэрээ байгууллаа. Уг гэрээгээр МАА-н ЭШХүрээлэн нь малчдын хонь, тэмээний ноосыг бэлтгэн нийлүүлэх стандартыг боловсруулахад судалгааны ажил хийх, сумын ЗДТГ хоршоодтой хамтран малчдынхаа мал ноослох, ялган ангилах ажлын баг гарган ажиллуулах, “Могол ноос” ХХК нь ноосыг татан авч ангилах, үйлдвэрт бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ. Ингэснээр малчид нь ноосны урамшуулалд найдвартай хамрагдах мөн хоршоодын үйл ажиллагааг дэмжих ач холбогдолтой ажил болно. | 100 |
| Цөөн малтай малчдыг малжуулах хөтөлбөрт хамруулж, малжуулах арга хэмжээг авна. | 36 | Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран улсын төсвөөс хэрэгжиж байгаа малжуулах төсөл, хөтөлбөрт цөөн малтай иргэдийг хамруулах бодлогыг хэрэгжүүлж ажиллана. | Малжуулах төсөлд хамрагдах хүсэлтээ гаргасан 10 иргэнийг үр тариа, малын тэжээлийн ургамал тариалах, мэдлэг дадлага олгох 3 хоногийн сургалтанд хамруулсан. Эдгээр иргэдээс малжуулах төсөлд хамрагдах төслийг авч эхлээд байна. Уг зээлд хамрагдсан малчин өрхөд 4-5 сая төгрөгийн 75-110 толгой мал олгоно.                                                                                                                                                                                                                                                                                                                                             | 100 |
|                                                                                | 37 | Сумын хэмжээнд иргэдийн хандив, тусламжаар малжуулах санг бий болгон холбогдох журмыг боловсруулж, цөөн малтай иргэдийг малжуулах арга хэмжээг авна.                | 1, 2, 4-р багууд багийн сангийн малаараа малжуулах ажлыг зохион байгуулж байна. Сумын ОНХС-аар "Төмөр сүрэг" малжуулах төслийг хөдөөгийн баг бүрт, жил бүр шилжүүлэн хэрэгжүүлж байна. Малжуулах сангийн малын тоог нэмэгдүүлж, цөөн малтай олон өрхийг малжуулах ажлыг хэрэгжүүлэхээр тооцоо судалгааны ажил хийгдэж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                              | 100 |

|                   |                                                                          |    |                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |      |
|-------------------|--------------------------------------------------------------------------|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                   | Сайнцагаан омгийг улсын хэмжээнд бий болгож, иргэдэд сурталчилгаа хийнэ. | 38 | Сайнцагаан омгийг бий болгож баталгаажуулах ажлыг зохион байгуулна.                                                       | Нутгийн шилмэл хонин сүрэг “Сайнцагаан” омгийг батлуулах судалгаа, шинжилгээний ажил явагдаж байна. МAA-н Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн МAA-н эрдмийн зөвлөл болон Их эрдмийн Зөвлөлийн хурлаар “Сайнцагаан” хонины ашиг шим, биологийн зарим үзүүлэлтийн судалгааны арга зүйг хэлэлцүүлж батлууллаа.<br>Хаврын тандалт судалгаа, шинжилгээний ажил хийгдэж, Далай багийн 12 малчин өрхөөс 12 хонины арьс, махны дээжийг авч, лабораторид явууллаа. Мөн 50 хонины цусны дээжийг шинжилгээнд хамрууллаа. | 100  |
|                   |                                                                          | 39 | Сайнцагаан омгийн цөм сүргийг бий болгож, зах зээлд борлуулах ажлыг зохион байгуулж малчдын орлогыг нэмэгдүүлнэ.          | Малчдын ХЭДС-ийн төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаа малчин өрхүүдэд мал нийлүүлэх саналыг нутгийн малчдаас хүлээн авч, баримт материалыг бүрдүүлж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | 70   |
|                   |                                                                          | 40 | Сайнцагаан хонины омгийн талаар баримтад кино, нэвтрүүлгийг бэлтгэж цацах, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна. | Хөдөөгийн багуудын нэгдсэн хурал, Төлчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөнд оролцогчдод мэдээллийг өгсөн. Үүнд 380 иргэн хамрагдсан. Мөн малчин өрхүүдээр явахад мэдээлэл, сурталчилгааг хийж, сумын малчид зохих хэмжээнд ойлголттой болсон. Цаашид нэвтрүүлэг, шторк зэргийг бэлтгэж олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.                                                                                                                                                            | 100  |
|                   |                                                                          | 41 | Гойд ашиг шимтэй малын улсын үзэсгэлэнд бэлтгэл ханган оролцоно.                                                          | хугацаа болоогүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |      |
| Хэрэгжилтийн хувь |                                                                          |    |                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | 90.3 |

Хэрэгжилтийг гаргасан:

"Орлоготой иргэн сум" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг